

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2016.12.24-2017.01.24/

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сумын төв шинэ жилийн баяр наадмыг 2016 оны 12-р сарын 30-ны өдөр 3-р сургуулийн спорт зааланд ёслол төгөлдөр тэмдэглэж сумын 2017 оны тэргүүний ажилтнуудаа шалгарууллаа. Үүнд:

2016 оны “Тэргүүний ажилтан”-аар

1. Д.Ганзориг – ЗДТГ-ын жолооч
2. Н.Оюунбилэг – ШОХК-ийн Чанар-экологич инженер
3. Р.Батжаргал –Илчлэг-Шивээ ОНӨҮГ-ын зуухны машинист нар тус тус шалгарсан бол

Засаг даргын баярын бичгээр:

1. С.Анхбаяр – ШОХК-ийн ээлжийн мастер
2. Г.Амарсайхан – 3-р цэцэрлэгийн багш
3. Б.Жасрайдорж - “Илчлэг-Шивээ” ОНӨҮГ-ын зуухны машинист
4. Ч.Гэрэлмаа – Эрүүл мэндийн төвийн сувилагч
5. Ц.Мөнхтуяа - 3-р сургуулийн бага ангийн багш нар тус тус шагнагдсан байна.



Шинэ жилийн баярын өдрүүдэд Засаг даргын захирамжаар сумын хэмжээний хариуцлагатай жижүүрийн хуваарь гарган хуваарийн дагуу албан байгууллагуудын дарга, ажилтан, албан хаагчид ажилласан.

Сумын Засаг даргын 2017 оны 01-р сарын 04-ний өдрийн А\01 тоот Захирамжаар цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулж сумын хэмжээнд нийт 892 иргэн хамрагдахаас 646 иргэн хамрагдаж 72,4 хувьтай бүртгэгдсэн байна.



Сумын ОНХС-ийн хөрөнгөнд нохой, муур устгах зардлыг тусган батлуулж 2-р багийн иргэнтэй гэрээ байгуулан нохой, муур устгах ажлыг зохион байгуулж 61 нохой, 5 муур устгасан.

Сумын Засаг даргын 2016 оны 11-р сарын 30-ний өдрийн А/146 тоот Захирамжаар 2016 оны жилийн эцсийн хүн ам, малын тооллогын ажлыг зохион байгуулах комисс томилогдон 3378 хүн ам, 43428 толгой мал тоологдсон нь урьд оноос хүн ам 125 өсч, мал 282 толгой буюу 0,7 хувиар буурсан байна.

Сумын засаг даргын 2017 оны 01-р сарын 16-ны өдрийн А\02 тоот Захирамжаар сумын “Хамтарсан баг”-ыг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна.

2017 оны ОНХС-ийн төлөвлөгөөг ИТХ-аар батлуулж сангийн яаманд хүргүүлсэн. Үүнд:

5 ажил, 2 бараа, 4 хөтөлбөр арга хэмжээний худалдан авалт хийгдэхээр батлагдсан.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн 2016 оны жилийн эцсийн мэдээг гаргаж ТЗУХ-т хүргүүлсэн.

Үүнд:

2016 онд Засаг дарга болон засаг даргын Тамгын газарт 82 өргөдөл, 1-р багт 7, 2-р багт 4, иргэний бүртгэлийн асуудлаар 1320 нийт 1413 өргөдөл хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэн ажилласан.

Бодлогын баримт бичгүүдийн 2016 оны жилийн эцсийн тайлан, мэдээг гаргаж холбогдох газруудад хүргүүлсэн. Үүнд: Монгол улсын үндсэн чиглэл, аймаг, сумын Эдийн засаг нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг дарга болон Шивээговь сумын Засаг даргын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээ, аймгийн цогц бодлого,


Засгийн газрын тогтоол, аймгийн ИТХ-ын Тогтоол, аймгийн Засаг даргын Захирамж, Засгийн газрын 143-р тогтоол, холбогдох эрх зүйн акт, гүйцэтгэл сайжруулах ажлын төлөвлөгөөний биелэлт зэрэг болно.

2017 онд зохион байгуулагдах дотоод эрх зүйн сургалтын төлөвлөгөө болон Хууль зүйн орон тооны бус албаны сургалтын төлөвлөгөөг гаргаж баталгаажуулсан. Мөн 2017 онд зохион байгуулагдах сумын “Удирдах ажилтаны шуурхай зөвлөгөөн”-ний хуваарийг гарган албан байгууллагуудад хүргүүлж шуурхай зөвлөгөөнийг 2017 оны 01-р сарын 10, 24-нд зохион байгуулж албан байгууллагуудын мэдээлэлтэй танилцан байгууллагуудын удирдлагуудад холбогдох чиглэлийн дагуу хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

3-Р СУРГУУЛЬ :

2016-2017 оны хичээлийн жилийн дунд, ахлах ангийн сурагчдын 2 дугаар улирлын дүнг өмнөх 3 жилийн 2 дугаар улирлын дүнтэй харьцуулбал:



Өмнөх жилийн 2-р улирлын стандарт хангалтаас энэ хичээлийн жилийн стандарт хангалт 2,7% -иар, АВ –гийн хувь 2% -иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2017 оны 1 дүгээр сарын 15–нд Говьсүмбэр аймагт зохион байгуулагдсан шатрын Цодгор хүү тэмцээнд 8 сурагч оролцсоноос 6б ангийн сурагч Хүсэлбаатар хүрэл медаль хүртсэн.



Хүйтний улирал эхэлсэнтэй холбогдуулан суралцагчдын ханиад, томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сурагчдад эрүүл мэндийн чиглэлээр мэдээ мэдээллийг өгч байна.



Ханиад томуугаар өвчилсөн хүүхэд ихсэж, бага, дунд ангийн сурагчдын хичээлийн ирц 48%-тай байна.

Сургуулийн бага ангийн корпусын 62 м халаалтын шугамыг шинэчлэх ажлыг байгууллагын нөөц бололцоогоор хийж гүйцэтгэсэн.

2017 оны 01 сарын 13, 14-нд Улсын клиникийн I эмнэлгийн эмч мэргэжилтнүүдийг сумандаа урьж сургууль, цэцэрлэгийн нийт 57 багш, ажилчидыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.



3-Р ЦЭЦЭРЛЭГ

Цэцэрлэгийн хүүхдийн ханиад томуугаар өвчилсөн өвчлөл ихсэж, хүүхдийн ирц 50%-иар буурч байна.

Иймд ханиад томуунаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг шат дарааллан авч байна. Үүнд:

Иллэг, давс, содатай уусмалаар хоолой зайлах, хүүхдийг витаминжуулах, жавелиноор ариутгах, өрөө тасалгааг кварцийн гэрлээр халдваргүйжүүлх, хүүхдийн ор дэвсгэрийн хэрэглэлийг салхинд гаргах, чийгтэй цэвэрлэгээ хийх зэрэг халдваргүйтгэлийн ажлыг өдөр бүр хийж байна. Хүүхдүүдэд халуун аарц, чацаргана, аньсыг өглөө, орой тогтмол өгч байна.

Сумын Эрүүл мэндийн эмч нар урьдчилан сэргийлэх үзлэг хийж, эцэг эхчүүдэд томуугаас урьдчилан сэргийлэх зөвлөгөө зөвлөмжийг өгч ажиллаж байна



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

- Эмнэлэгт хэвтсэн - 176 үүнээс хүүхэд-155, дотор-21
- Амбулаторийн үзлэг - 674
- Урьдчилан сэргийлэх –210
- Дуудлага- 262

Эрүүл мэндийн төвийн хэвтэн эмчлүүлэгчдийн хоол хүнсний материал, эм тарианы нөөц дуусч, эмчилгээ үйлчилгээ тасалдалд хүрээд байна. Томуу томуу тест өвчний дэгдэлт 01 сарын 09-нөөс 13-ны хооронд хамгийн өндөр 20%-25%-д хүрч, сарын сүүлийн 7 хоногийн байдлаар өвчний дэгдэлт буураад байна. Энэ нь эцэг эхчүүд бага насны хүүхдүүдээ хичээл, цэцэрлэгт нь явуулахгүй, гэрийн асаргаанд байлгаж, асарсантай холбоотой гэж дүгнэж байна.

2017 оны 01 сарын 16-ны өдөр Швейцарын хөгжлийн агентлаг, Дэлхийн банкны хөрөнгө оруулалттай, “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хэнийг ч орхигдуулахгүй байх нь” сэдэвт төслийн нээлтэнд Эрүүл мэндийн төвийн дарга, нийгэм эрүүл мэндийн ажилтан мөн төслийн сургалтанд эрүүл мэндийн төвийн 12 ажилтан хамрагдсанаар Монголын нийгмийн эрүүл мэндийн нийгэмлэг, ГСА-ийн ОНОШ төрийн бус байгууллагатай хамтран төслийг хэрэгжүүлэхээр болоод байна.



Сумын Ахмадын хороо нь соёлын төвтэй хамтран ахмадын аэробек, хийн дасгал хөдөлгөөнөөр хичээллэж эхлээд байна.

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 04 тоот тогтоолоор “Амьжиргааг дэмжих орон тооны бус” зөвлөл 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Зөвлөлийн гүшүүдэд аймгийн ХХҮГ-ын халамжийн сан, тэтгэвэр тэтгэмж хариуцсан мэргэжилтэн нар 1-р сарын 23-ны өдөр сургалт зохион байгуулсан.

Хүнсний эрхийн бичигт хамрагдаж буй 8 өрхийн 12-р сарын 461500 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг гэрээ байгуулсан дэлгүүрээр дамжуулан олгосон.

НИЙГМИЙН ДААТГАЛ

2017 онд сайн дурын даатгалд нийт 175 иргэнийг хамруулсан. Үүнд:

Малчин-72, ажилгүй-73, оюутан-10, хувиараа бизнес эрхлэгч-20 иргэнийг тус тус даатгалд хамруулсан байна.

УЛСЫН БҮРТГЭЛ

Иргэний бүртгэлийн үйлчилгээг 110 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 12 иргэн бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.

2017 оны 01 сарын 24-ны байдлаар газраа анх удаа өмчилж авч байгаа 3 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн гэрчилгээг олгоод байна.

Иргэдээс 01-р сард иргэний бүртгэлтэй холбоотой 77, газартай холбоотой 3 нийт 80 өргөдөл хүлээн авсныг хугацаанд нь шийдвэрлэсэн.

Иргэний гэр бүл байдлын статистик мэдээ тайлан болон Иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үнэт цаасны тайлан, үнэт цаасны орлогын тайлан зэргийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

2017 оны 1-р сард 361500 төгрөгийн орлогыг оруулж улсын бүртгэл, статистикийн газрын дансанд 207500, сумын тэмдэгтийн хураамжийн дансанд 88700 төгрөгийг тус тус байршуулж ажилласан.

ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2017 ОНЫ 01 САРЫН МЭДЭЭ

	м/ д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгт эй	Эмэгт эй	Бүгд	Эрэгт эй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	6				6	3	3
Төрсөн эх	2	6				6	-	6
Бүртгүүлсэн гэр бүл	3	-				-	-	-
Нас баралт	4	1				1	1	-
Цуцалсан гэр бүл	5	-				-	-	-
Үрчлэгдсэн хүүхэд	6	-				-	-	-
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	11				11	7	4
Аймаг, нийслэл рүү шилжин явсан	8	14				14	7	7

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОРСОН ОРЛОГО**

Д/Д	Үйлчилгээний нэр төрөл	2017 оны 1-р сар					Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 30020002210 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 30030012313 8 тоот дансанд			
		Нэг бүрийн н үнэ	Тоо		Нэг бүрийн н үнэ	Тоо		
1	Эцэг тогтоолт	2500	1	2500				
2	ᠣᠳᠡᠨᠢᠶᠡᠭᠢᠨᠨᠡᠭᠡᠢᠨ ᠠᠠᠳᠡᠨᠢᠶᠡᠭᠢᠨᠨᠡᠭᠡᠢᠨ	5000	1	10000				
3	Иргэний үнэмлэхний үнэ	15000	19	195000	3300	19	62700	
4	ᠶᠡᠨᠨᠢᠯᠢᠰᠢᠨᠨᠡᠭᠡᠢᠨ ᠶᠡᠨᠨᠢᠯᠢᠰᠢᠨᠨᠡᠭᠡᠢᠨ	5000	8	5000	1000	8	8000	
5	өөр аймаг луу шилжин явсан	2500	2	5000	1000	2	2000	
6	Аймаг доторх шилжилт хөдөлгөөн	1500	16	2000	1000	16	16000	
ДҮН		207500			88700			
НИЙТ ДҮН		361500						

МАЛ ЭМНЭЛЭГ ҮРЖЛИЙН ТАСАГ

Монгол улсын Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолын дагуу 2016 онд сумын арьс бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдийн мэдээг програмид шивж оруулж архивын нэгж үүсгэн аймгийн ХХААГазарт хүргүүлсэн.

Жилийн эцсийн тооллогоор суманд 56 худаг, 21 гахай, 11 шувуу, 43428 толгой мал тоологдсон байна. Үүнд: Тэмээ – 92, Адуу – 1520, Үхэр – 1581, Хонь – 19288, Ямаа – 21229 сумын мал өнгөрсөн жилийнхээс 0.7 %-иар буурсан байна.

МЭДЭЭ ГАРГАСАН:

НЗЭЗАХМ

О.БОЛОРМАА